



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 1 дүгээр сарын 04 өдөр

Дугаар 01

Хэрлэн сум

I ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 1 дүгээр хуралдаан 2021 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 80,4 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Коронавирус халдварт өвчний одоогийн нөхцөл байдлын мэдээлэл танилцуулах,

*Эрүүл мэндийн газар*

2.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуй нэгж байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичгийг танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*



3.Зөвшөөрөлгүй тээврийн хэрэгслээр хот хоорондын тээвэрлэлт хийж байгаа талаар мэдээлэл танилцуулах,

*Гаалийн газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа нарт:

1.1.Аймгийн Онцгой комиссын шуурхай штабын байрнуудыг шалгах ажлыг мэргэжлийн байгууллагууд хамтран зохион байгуулахыг,

/  / М.Бадамсүрэн  
/  / Э.Ганжигүүр



Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,

1.2.Аймгийн хэмжээнд түргэвчилсэн болон PCR шинжилгээ, давтан шинжилгээнд хамрагдсан иргэдийн мэдээллийг нэгтгэж өдөр бүр аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргад танилцуулахыг,

Хоёр.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой  
комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг нарт:

2.1.“ТВЕА” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Улаанбаатар хот руу нэвтрүүлэх хүсэлт”-ийн дагуу Хөлөнбуйр сумын хяналтын цэгээр нэвтрүүлэх,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Авто тээврийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Мөнхтөр нарт:

2.2.“ТВЕА” ХХК-ийн ажилчдыг Улаанбаатар хот руу хүргэх тээврийн хэрэгсэл, жолоочийг судалж шуурхай штабын хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой  
комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.3.Цагаан-Овоо сумын Засаг даргаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Улаанбаатар хотоос Дорнод аймагт нэвтрэх хүсэлт”-ийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 226 дугаар тогтоолыг үндэслэн хариу мэдэгдэхийг,

2.4.“Доц” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Улаанбаатар хот руу нэвтрэх хүсэлт”-ийн дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримталж Хөлөнбуйр сумын хяналтын цэгээр нэвтрүүлэхийг,

Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг-т:

2.5.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд зөрчил гаргасан иргэн, аж ахуй нэгжид тухай бүрт хариуцлага тооцож ажиллахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

2.6.Дээд шатны байгууллагуудаас коронавируст халдвар /Ковид-19/-тай холбогдуулан гаргасан тогтоол, шийдвэр, журмуудыг сумын Онцгой комисс, шуурхай штаб, хяналтын цэгүүдэд хүргүүлэхийг,

2.7.Буяны ажилд оролцох иргэдийн мөрдөх журмыг Онцгой байдлын газраас санал авч боловсруулж батлуулахыг,

/  / М.Бадамсүрэн  
/  / Э.Ганжигүүр



Гурав. Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Авто тээврийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Мөнхтөр нарт:

3.1.Зөвшөөрөлгүй тээврийн хэрэгсэл, хулгайн замаар хот хоорондын тээвэрлэлт хийж байгаа иргэдийн хяналтыг эрчимжүүлж ажиллахыг,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,  
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн  
цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Авто тээврийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Мөнхтөр нарт:

4.1.Дээд шатны байгууллага болон Хэнтий, Багануур дүүрэг, Налайх дүүргүүдийн ижил шатны байгууллагуудад хот хоорондын тээврийн талаар мэдээлэл солилцох, хамтран ажиллах талаар албан бичиг хүргүүлэхийг,

Аймгийн Засаг даргын орон тооны  
зөвлөх Х.Энх-Отгон-д:

4.2.Хот хоорондын тээвэр, хяналтын цэгийн хяналтыг сайжруулах гар утсанд ашиглах аппликешн судалж танилцуулахыг,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.3.Хөлөнбуйр сумын хяналтын цэгийн вагончикт иргэдийг тусгаарлах хаалт хийж байршуулахыг,



4.4.Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглох тухай аймгийн Онцгой комиссын тогтоол боловсруулж батлуулахыг,

АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх-д:

4.5.Хөрш зэргэлдээ аймгуудын удирдлагатай хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах тухай цахим хурал зохион байгуулахыг,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

4.6.Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны самбарт бэлтгэж дараагийн аймгийн Шуурхай штабын хуралд танилцуулахыг,

 / М.Бадамсүрэн  
 / Э.Ганжигүүр



АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн  
мэргэжилтэн О.Гүнтамир-д:

4.7. Хот хоорондын шуудан үйлчилгээг сурталчилах самбар, үзүүлэх бэлтгэж дараагийн аймгийн Шуурхай штабын хуралд танилцуулахыг тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН  
ДАРГА М.БАДАМСҮРЭН



БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ПРОГРАММ, ТЕХНИК ХАНГАМЖ ХАРИУЦСАН  
ИНЖЕНЕР, АХМАД *Э.Танжигүүр* Э.ТАНЖИГҮҮР